

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Цогт-Овоо сум дахь сум дундын ойн ангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2026/014/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг 2026 он</p>	<p>Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Шижирболд Утас: 70533552 Цахим хаяг: umnugovi@audit.gov.mn Азуре хүлүг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Г.Мөнхбаяр Утас: 70110090 Цахим хаяг: audit@azure.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.25 № 132
танай _____-ны № _____-т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТ-ОВОО
СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ОЙН
АНГИЙН ДАРГА П.НАРАНБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Цогт-Овоо сум дахь сум дундын ойн ангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Эрх бүхий байгууллагын шийдвэрээр Цогт-Овоо сумын Засаг даргын Тамгын газраас 125,750.0 мянган төгрөгийн автомашин, тоног төхөөрөмжийг шилжүүлэн авсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд мод үржүүлгийн талбайн үйл ажиллагааны зардлын зориулалтаар 326,803.7 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна.

Бусад асуудал хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 3 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 90.5 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

4626050216

Р.12 Бичиг хэрэг/2026он/СТА-н дүгнэлт/Төсвийн бичиг

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/			
Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	693,309,717.90	766,577,120.57
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
33	АВЛАГА	224,985,477.90	396,819,570.57
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,845,839.90	29,519.57
335	Бусад авлага	223,139,638.00	396,790,051.00
3351	Байгууллагаас авах авлага	223,139,638.00	396,790,051.00
35	БАРАА МАТЕРИАЛ	429,374,240.00	350,707,550.00
354	Хангамжийн материал	429,374,240.00	350,707,550.00
3541	Бичиг хэргийн материал	-	130,500.00
3542	Аж ахуйн материал	61,000.00	-
3544	Түлш, шатах тослох материал	1,250,000.00	-
3547	Бусад хангамжийн материал	428,063,240.00	350,577,050.00
36	НӨӨЦИЙН БАРАА	38,950,000.00	19,050,000.00
362	Үрийн нөөц	38,950,000.00	19,050,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	664,409,502.28	682,963,832.31
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	664,409,502.28	682,963,832.31
392	Биет хөрөнгө	662,979,502.28	681,698,832.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	319,585,000.00	319,585,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,089,875.01)	(40,168,375.13)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	241,820,000.00	367,570,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(24,683,611.07)	(93,225,277.79)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	118,744,500.00	134,904,500.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,293,833.32)	(17,572,066.53)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,112,700.00	12,112,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(215,378.32)	(1,507,648.24)
393	Биет бус хөрөнгө	1,430,000.00	1,265,000.00
39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(220,000.00)	(385,000.00)
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,357,719,220.18	1,449,540,952.88
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Өглөг	-	-
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,357,719,220.18	1,449,540,952.88
51	Засгийн газрын хувь оролцоо	1,357,719,220.18	1,449,540,952.88
512	Хуримтлагдсан үр дүн	1,357,719,220.18	1,449,540,952.88
5121	Өмнөх үеийн үр дүн	1,357,719,220.18	1,357,719,220.18
5122	Тайлант үеийн үр дүн		91,821,732.70
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,357,719,220.18	1,449,540,952.88

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/			
Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,593,959,821.00	761,122,302.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	996,744,940.00	89,072,916.55
120	Нийтлэг татварын бус орлого	996,744,940.00	89,072,916.55
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	583,397,700.00	89,072,916.55
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	413,347,240.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	597,214,881.00	672,049,386.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	373,467,181.00	366,021,025.00

**Өмнөговь аймгийн Цогт-Овоо сум дахь сум дундын ойн ангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,504,207.00	37,141,712.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,543,274.00	2,075,613.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	335,419,700.00	326,803,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	223,747,700.00	306,028,361.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	223,747,700.00	306,028,361.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	336,207,889.72	669,300,569.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	336,207,889.72	669,300,569.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	317,342,479.97	652,140,119.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	241,242,064.30	343,763,751.41
210101	Үндсэн цалин	124,278,994.20	141,702,562.41
210102	Нэмэгдэл	52,554,550.80	98,659,693.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	7,977,000.00
210104	Урамшуулал	23,555,500.00	43,726,887.00
210105	Гэрээт ажлын хөлс	40,853,019.30	51,697,609.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,712,611.23	39,796,002.72
210201	Тэтгэврийн даатгал	15,678,090.23	26,721,892.22
210202	Тэтгэмжийн даатгал	2,210,520.00	3,179,336.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,818,820.00	2,324,975.00
210204	Ажилгүйдлийн даатгал	580,039.00	1,042,240.50
210205	Эрүүл мэндийн даатгал	4,425,142.00	6,527,558.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,407,686.82	3,162,239.10
210301	Гэрэл, цахилгаан	2,407,686.82	3,162,239.10
2104	Хангамж, бараа материалын зардал	10,769,000.00	17,386,400.00
210401	Бичиг хэрэг	471,900.00	1,022,300.00
210402	Тээвэр, шатахуун	8,884,500.00	14,605,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	825,000.00	1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	587,600.00	758,500.00
2105	Нормативт зардал	350,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	350,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,321,300.00	18,837,450.00
210604	Урсгал засвар	11,321,300.00	18,837,450.00
2107	Томилолт, зочны зардал	1,440,000.00	1,440,000.00
210702	Дотоод албан томилолт	1,440,000.00	1,440,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,563,231.00	1,644,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,563,231.00	1,644,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,536,586.62	226,109,876.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	139,431,290.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,536,586.62	86,678,586.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,865,409.75	17,160,450.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,632,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,536,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,095,500.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,230,135.75	16,907,572.03
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,230,135.75	16,907,572.03
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,274.00	252,878.07
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,274.00	252,878.07
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,257,751,931.28	91,821,732.70
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,257,751,931.28	91,821,732.70

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/			
Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	597,214,881.00	895,189,024.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	597,214,881.00	895,189,024.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	373,467,181.00	589,160,663.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,504,207.00	37,141,712.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,543,274.00	2,075,613.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	335,419,700.00	549,943,338.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	223,747,700.00	306,028,361.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	223,747,700.00	306,028,361.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	597,214,881.00	879,029,024.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	597,214,881.00	879,029,024.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	355,209,833.25	465,078,522.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	243,489,971.00	337,509,734.48
210101	Үндсэн цалин	125,140,871.20	133,746,738.32
210102	Нэмэгдэл	52,154,533.80	100,159,732.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	7,977,000.00
210104	Урамшуулал	24,840,766.00	43,726,887.00
210105	Гэрээт ажлын хөлс	41,353,800.00	51,899,377.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,310,544.43	41,733,699.32
210201	Тэтгэврийн даатгал	15,641,190.13	28,869,583.82
210202	Тэтгэмжийн даатгал	2,240,526.00	3,230,400.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,370,223.00	1,956,914.00
210204	Ажилгүйдлийн даатгал	751,330.00	1,166,662.50
210205	Эрүүл мэндийн даатгал	4,307,275.30	6,510,138.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,407,686.82	3,162,239.10
210301	Гэрэл, цахилгаан	2,407,686.82	3,162,239.10
2104	Хангамж, бараа материалын зардал	12,159,100.00	16,735,900.00
210401	Бичиг хэрэг	700,000.00	1,682,800.00
210402	Тээвэр, шатахуун	10,134,500.00	13,355,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	825,000.00	1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	499,600.00	697,500.00
2105	Нормативт зардал	750,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	750,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,932,800.00	22,237,450.00
210604	Урсгал засвар	11,932,800.00	22,237,450.00
2107	Томилолт, зочны зардал	1,440,000.00	1,440,000.00
210702	Дотоод албан томилолт	1,440,000.00	1,440,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,563,231.00	2,134,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,563,231.00	2,134,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,156,500.00	40,125,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,156,500.00	40,125,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	242,005,047.75	413,950,501.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,632,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,536,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,095,500.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,230,135.75	16,907,572.03
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,230,135.75	16,907,572.03

**Өмнөговь аймгийн Цогт-Овоо сум дахь сум дундын ойн ангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	223,142,912.00	397,042,929.07
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	223,142,912.00	397,042,929.07
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	16,160,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	16,160,000.00
	Дотоод эх үүсвэрээр	-	16,160,000.00
223001	Бусад хөрөнгө	-	16,160,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(16,160,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,357,719,220.18	1,357,719,220.18
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Тайлант үеийн үр дүн	-	-	91,821,732.70	91,821,732.70
4	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,449,540,952.88	1,449,540,952.88

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	300,019,700.00	289,120,788.97	10,898,911.03
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	300,019,700.00	289,120,788.97	10,898,911.03
132001	Орон нутгийн төсвөөс	300,019,700.00	289,120,788.97	10,898,911.03
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	300,019,700.00	289,120,788.97	10,898,911.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	300,019,700.00	289,120,788.97	10,898,911.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	299,219,700.00	289,120,788.97	10,098,911.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252,559,200.00	250,021,815.07	2,537,384.93
210101	Үндсэн цалин	114,612,000.00	113,648,657.91	963,342.09
210102	Нэмэгдэл	98,987,200.00	100,159,732.16	(1,172,532.16)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,660,000.00	7,977,000.00	1,683,000.00
210104	Урамшуулал	10,300,000.00	10,137,048.00	162,952.00
210105	Гэрээт ажлын хөлс	19,000,000.00	18,099,377.00	900,623.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,449,900.00	30,811,734.80	638,165.20
210201	Тэтгэврийн даатгал	21,529,900.00	21,160,959.30	368,940.70
210202	Тэтгэмжийн даатгал	2,480,000.00	2,470,060.50	9,939.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,240,000.00	1,257,224.00	(17,224.00)
210204	Ажилгүйдлийн даатгал	1,240,000.00	991,168.50	248,831.50
210205	Эрүүл мэндийн даатгал	4,960,000.00	4,932,322.50	27,677.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,400,000.00	3,162,239.10	237,760.90
210301	Гэрэл, цахилгаан	3,400,000.00	3,162,239.10	237,760.90
2104	Хангамж, бараа материалын зардал	7,875,000.00	4,119,600.00	3,755,400.00

Өмнөговь аймгийн Цогт-Овоо сум дахь сум дундын ойн ангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210401	Бичиг хэрэг	1,150,000.00	531,000.00	619,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,300,000.00	2,277,600.00	3,022,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	960,000.00	1,000,000.00	(40,000.00)
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	465,000.00	311,000.00	154,000.00
2105	Нормативт зардал	500,000.00	-	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	-	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,050,000.00	600,000.00	450,000.00
210604	Урсгал засвар	1,050,000.00	600,000.00	450,000.00
2107	Томилолт, зочны зардал	550,000.00	-	550,000.00
210702	Дотоод албан томилолт	550,000.00	-	550,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,835,600.00	405,400.00	1,430,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,835,600.00	405,400.00	1,430,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	800,000.00	-	800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	-	800,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	800,000.00	-	800,000.00
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	300,019,700.00	289,120,788.97	10,898,911.03
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/ төгрөгөөр/	
Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл	
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	192,117,733.93	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	192,117,733.93	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,141,712.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,075,613.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	152,900,408.93	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	192,117,733.93	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	588,907,784.93	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	192,117,733.93	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	87,487,919.41	
210101	Үндсэн цалин	20,098,080.41	
210104	Урамшуулал	33,589,839.00	
210105	Гэрээт ажлын хөлс	33,800,000.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,921,964.52	
210201	Тэтгэврийн даатгал	7,708,624.52	
210202	Тэтгэмжийн даатгал	760,340.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	699,690.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	175,494.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	1,577,816.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	13,276,300.00	
210401	Бичиг хэрэг	1,811,800.00	
210402	Тээвэр, шатахуун	11,078,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	386,500.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,637,450.00	
210604	Урсгал засвар	21,637,450.00	
2107	Томилолт, зочны зардал	1,440,000.00	
210702	Дотоод албан томилолт	1,440,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,729,000.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,729,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,625,100.00	

Өмнөговь аймгийн Цогт-Овоо сум дахь сум дундын ойн ангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,625,100.00
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	192,117,733.93
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 16,189.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 16,189.5 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- "Мөнгөн гүйлгээний тайлан" дахь биет ба биет бус нь хөрөнгө худалдан авах зардлын дүн нь "Үндсэн хөрөнгийн тайлан"-ийн худалдаж авсан хөрөнгийн дүнгээс 16,160.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, тайлангийн уялдааг хангаагүй байна.
- Тус байгууллагын цалингийн тооцооллыг нийгмийн даатгалын тайлантай тулгаж шалгахад даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг 29.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Аудитаар нийт мянган 632.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 632.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 19,733.8 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
								Үүнээс		Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	"Мөнгөн гүйлгээний тайлан" дахь биет ба биет бус нь хөрөнгө худалдан авах зардлын дүн нь "Үндсэн хөрөнгийн тайлан"-ийн худалдаж авсан хөрөнгийн дүнгээс 16,160.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, тайлангийн уялдааг хангаагүй байна.	1	16,160.0	1	16,160.0	-	-	1	16,160.0	-	-	-	-
2	Тус байгууллагын цалингийн тооцооллыг нийгмийн даатгалын тайлантай тулгаж шалгахад даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг 29.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	29.5	-	-	1	29.5	1	29.5	-	-	-	-
	Дүн	2	16,189.5	1	16,160.0	1	29.5	2	16,189.5	-	-	-	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шатахууны зарцуулалтын ажил гүйлгээг жолоочийн тооцооны хуудас, шатах тослох материалын тайлантай тулгаж шалгахад 632.0 мянган төгрөгийн илүү зарцуулалт бүртгэсэн байна.	1	632.0	1	632.0	-	-	-	-	-	-	-	-
	Дүн	1	632.0	1	632.0	-	-	-	-	-	-	-	-